

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

(2021 оны жилийн эцэс)

Байгууллагын нэр: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Огноо: 2022.01.31

Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хоёр дахь үе шат (2020 - 2023) хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, Хэрэгжилтийн хувь
<p>Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</p>						
1	<p>4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p>1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох</p>	2017 - 2022	-	<p>1. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийн мэдээллийн санг хөгжүүлсэн байх</p> <p>2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн системийг хөгжүүлсэн байх</p>	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Албан тушаалд томилохдоо төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэгдсэн иргэд болон төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа иргэдээс зохих журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулсны дүнд томилох арга хэмжээ аван ажилласан. Тайлант хугацаанд 9 албан тушаалын сул орон тоог зарласны дагуу Төрийн албаны зөвлөлөөс зохих журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийн дагуу албан тушаалд томилох шийдвэр "арган ажилласан байна. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийн хүний нөөцийн ил тод байдал цэсэнд багруулан мэдээлж байна.</p> <p>Мөн авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан тушаалд нэр дэвшигч этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем https://meduuleg.iaac.mn -ээр дамжуулан хүлээн авч бүртгэн, АТГ-т цахим хэлбэрээр хүргүүлэн хянуулж хэвлээ. АТГ-ын хянасан дүгнэлтийн</p>

					<p>холбогдох мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийн хүний нөөцийн ил тод байдал цэсэнд байршуулан мэдээлж байна</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 хувь</p>
2		<p>5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох</p>	2017 - 2022	<p>Хүний нөөцийн системтэй уялдсан "Төрийн албаны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийн сан"-г хөгжүүлсэн байх</p>	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>2021 онд ТӨБЗГ-ын албан тушаалын жагсаалт, албан тушаалд шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн байдалтай холбоотой албан хаагчийн шилжилт, хэдөлгөөний судалгааг Хүний нөөцийн системтэй уялдуулан шинэчлэн гаргаж, байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийн хүний нөөцийн ил тод байдал цэсэнд байршуулан мэдээлэх арга хэмжээ авч байна. Байгууллагын цахим хуудасны шинэчлэлийн ажлыг хийж байгаатай холбоотой зарим мэдээллийг шигжүүлэн байршуулах, өөрчлөх ажлуудыг мөн хийж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 хувь</p>
3	<p>4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	2017 - 2022	<p>1. Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх</p> <p>2. Шалгуурт нийцсэн ТЖАХ-ийн эзлэх хувь - 70%-аас дээш</p>	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>2019 оноос мөрдөж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох гарсан журам, дүрмийн дагуу тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн захиргааны 20 албан тушаалын тодорхойлолтыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулж, батлах зөвшөөрөл авсан. Уг зөвшөөрлийн дагуу ТӨБЗГ-ын даргын 2021 оны А/07, А/08, А/09 дүгээр тушаалаар уг албан тушаалын тодорхойлолтуудыг тус тус батлан мөрдүүлэв.</p> <p>Албан тушаалын тодорхойлолтод заасан ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн тус байгууллагын сул орон тооны 9 албан тушаалд томилогдох иргэдийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэн ирүүлсэн шийдвэр, дүгнэлтийн дагуу томилох ажлыг зохион байгуулж байна.</p>

					Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд тавигдах тусгай шаардлага, шалгуурыг үндэслэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, томилох тогтолцоо бүрдсэн. Өөрийн үнэлгээ: 100 хувь
4	4.1.1.9. Төрийн байгууллага	1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	2017 - 2022	Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх	ТӨБЗГ – МТА (Бүх шатны төрийн байгууллага) Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны http://docx.gov.mn системд холбогдсон. Өөрийн үнэлгээ: 100 хувь
5	хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах	2018 - 2022	Байгууллагуудын мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн байх	ТӨБЗГ – МТА (АТГ, холбогдох бусад байгууллага) Төрийн болон орсон нутгийн өмчийн нэгдсэн системийг боловсронгуй болгох ажлыг эхлүүлэхтэй холбогдсон судалгааг хийсэн. Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны http://docx.gov.mn системийг байгууллагад хэрэглэж байгаа дотоод сүлжээний https://www.able.mn системтэй холбон ажиллуулж байна. Өөрийн үнэлгээ: 100 хувь
6	4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд:	2018 - 2022	Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36337 албан хаагчийг давтан сургасан байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг судалж, Авлигатай тэмцэх газрын УССГХ-т сургалтын санал нэгтгэн өгч, АТГ-ын болон ТӨБЗГ-ын сургалтын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан. АТГ-т саналыг 2 дугаар сард өгч, АТГ-ын хүсэлтээр 5 дугаар сард шинэчлэн тодотгосон. Уг захиалгад ТӨБЗГ-ын 50 албан хаагчийг, төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 40 хараат бус гишүүнийг авлигын эсрэг сургалтад хамруулах, төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг

					<p>бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ы семинарыг тус тус тусгасан. ТӨБЗГ-ын харьяа төрийн өмчит 19 хуулийн этгээдээс ирүүлсэн сургалт, семинарын саналыг нэгтгэж, нийт 473 хүнийг авлигын эсрэг сургалтад, 10 хүнийг сургагч багшийн сургалтад хамруулж, 2 байгууллагад тодсрхой сэдвийн хүрээнд семинар хийх талаар саналыг мөн АТГ-г хүргүүлсэн.</p> <p>2021.11.09-ний өдөр АТГ-т айлант жилийн 4 дүгээр улирлын сургалтын захиалга өгч, тодотгол хийсэн. Үүнд: ТӨБЗГ-ын 9 албан хаагчийг анхан шатны, 18 албан хаагчийг давтан сургалтад хамруулахаар төлөвлөгөөг тодотгосон боловч Төрийн албаны тусгай шалгалттай давхацсанаар анхан шатны сургалтад хамрагдах албан хаагчдын сургалт цуцлагдсан. Нийт 2 албан хаагчийг АТГ-ын Олон нийтийн төвд давтан сургалтад хамруулаад байна (ЗУХ-ийн дарга, хуулийн мэргэжилтэн) Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө цар тахлын үеийн нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалан бүрэн хэрэгжээгүй.</p> <p>АТГ-аас 2021.12.08-ны өдөр зохион байгуулсан "Авлигын эсрэг үндэсний чуулган"-д ЗУХ, ТӨУЗХ-ийн дарга нарыг хамруулав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын холбогдох албан хаагчид, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монгогросцветмет" ТӨҮГ-ын давхардсан тоогоор 40 албан хаагчийг хамруулсан байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 хувь</p>
Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх					
7	4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож,	2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2018 - 2022	Сүлжээний хэвийн ажиллагааг хангасан байх	<p>ТӨБЗГ – МТА (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>ТӨБЗГ-аас иргэдэд шууд хүрдэг үйлчилгээ байхгүй.</p> <p>Байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийг шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлж, иргэдэд хүргэх мэдээллийн нээлттэй, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх арга</p>

	бэхжүүлэх					хэмжээг авч хэрэгжүүлж байна. Өөрийн үнэлгээ: 100 хувь
8	4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	2018 - 2022		Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн байх	ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга) ТӨБГ-т зөвшөөрөл олгох чиг үүрэг хуулиар олгогдоогүй. Хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх шаардлага байгууллагын чиг үүргийн шинжилгээгээр тодорхойлогдоогүй. Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.
9	4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх	2018 - 2020		Стандартыг хангуулах сургалт зохион байгуулсан байх	ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ (Үндсэн хэрэгжүүлэгч: ЗГХЭГ, МХБ, СХЗГ, ТӨБЗГ) Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.4-2 дахь хэсэгт тусгагдсан хэд хэдэн байгууллагын оролцоотой хэрэгжих "Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх" гэсэн энэ арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хүсэлтийн дагуу байгууллага дундын ажлын хэсэгт ажиллах 3 албан хаагчийн нэрийг 2021 оны А-2/890 дугаартай албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн. Төрийн өмчийн хяналт шалгалтын чиг үүргийн дагуу тайлант жилд нийт дүнгээр 38 хуулийн этгээдэд хуульд заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Үүнээс: – Баримтын хяналт шалгалтад – 1 хуулийн этгээд; – Системийн хяналт шалгалтад – 11 хуулийн этгээд; – Гүйцэтгэлийн хяналт шалгалтад – 10 хуулийн этгээд; – Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад – 6 хуулийн этгээд. Эдгээр хяналт шалгалтын ажлын хүрээнд өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжид санхүүгийн сахилга батыг

					хэвшүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг тусгасан болно. Өөрийн үнэлгээ: 70 хувь
10		3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2018 - 2022	Хяналт шалгалтын тзог цөөрсүүлсэн байх	ТӨБЗГ – ТӨХШХ (Бүх шатны төрийн байгууллага) Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хийх төрийн өмчийн хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэх чиглэл барьж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу 2021 онд хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлсэн. Хяналт шалгалтын хүрээнд санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдлийг бууруулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 146 арга хэмжээ бүхий үүрэг даалгавар, 141 арга хэмжээ бүхий зөвлөмж өгч, шалгалтын явцад зөвлөн туслах чиглэлээр сургалт хийж зөвлөгөө өгч урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажилласан. Мөн зөрчлөөс урьдчилан сэргийлж эрсдлийг бууруулах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдүүдэд 2021.01.14-ны А-1/66 албан бичгээр албан даалгавар хүргүүлэн биелэлтийг хангуулж, тайланг хүлээн авч нэгтгэн дүгнэсэн. Өөрийн үнэлгээ: 100 хувь
11	4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	2017 - 2022	Үнэлгээ хийлгэх ажиг хэвшсэн байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн талаар "Хэрэглэгчийн үнэлгээ" хийсэн бөгөөд судалгаанд оролцогч 47 иргэний 19 хувь нь маш сайн, 72 хувь нь сайн, 9 хувь нь дунд гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд үнэлгээний дундаж үнэлгээ 4.1 буюу "сайн" гэж дүгнэгдсэн дүнтэй байна. ТӨБЗГ нь АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг төрийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-нд хамрагдсан. Уг үнэлгээний судалгааны ажлыг гүйцэтгэсэн ТББ-д дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтаар хангаж, хамтран ажилласан. Нийт 120 гаруй хүнээс асуумж хэлбэрээр авсан судалгааны үнэлгээний дүнгээр тус байгууллага нь улсад 5-д, Засгийн газрын агентлагийн дүнгээр 3-т эрэмбэлэгдсэн

						байга. Өөрийн үнэлгээ: 100 хувь
12		2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	2018 - 2019			ТӨБЗГ – ЗУХ (Төрийн үйлчилгээний байгууллага) ТӨБЗГ-аас иргэдэд шууд хүрдэг үйлчилгээ байхгүй. Төрийн үйлчилгээний байгууллагад хамаарах арга хэмжээ. Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.

Зорилт 3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх

13	4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх	2017 - 2019			ТӨБЗГ – ТӨБАХ (Үндсэн хэрэгжүүлэгч: ТӨБЗГ) Төрийн өмчит хуулийн этгээдтэй эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г байгуулж, жил бүр дүгнэж байна. Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан ТӨБЗГ-ын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гэрээг цахимаар шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд шаардагдах баримт, материалыг цахим хэлбэрээр хүлээн авч, дүгнэсэн бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулсан. "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийн 2020 оны улсын дундаж дүн 93.03 хувьтай байгаа нь өнгөрсөн оныхоос 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд 985 хуулийн этгээдтэй "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулсан. Төрийн өмчийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд тайлант жилд төрийн өмчит 38 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн бөгөөд төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад дүн шинжилгээ хийж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай шийдвэрт хслбогдох үүрэг даалгаврыг тусган тухайн байгууллагад хүргүүлж, хяналт тавин ажилласан. Энэ чиглэлээр санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдлийг бууруулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 146 арга хэмжээ
----	--	--	-------------	--	--	---

						<p>бүхий үүрэг даалгавар, 14* арга хэмжээ бүхий зөвлөмж өгч ажилласан байна.</p> <p>Засгийн газраас өгсөн чиглэл, үүргийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 87 хуулийн этгээдийн 2020 он, 2021 оны эхний 2 сарын байдлаарх тухайн хуулийн этгээдээс цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлтгэсэн хөрөнгө, бараа материалын судалгааг авч, зориулалт зарцуулалт, зарцуулсан зардлын байдалд дүн шинжилгээ хийсэн. Судалгаагаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 78 компани, төрийн өмчит үйлдвэрийн газар нийт дүнгээр 6.7 тэрбум төгрөгийн 514 нэр төрлийн бараа материал, ажил үйлчилгээ худалдан авсан дүнтэй байв.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
14	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах	2017 - 2019			<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Засгийн газрын тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжсэн ажил, төсөл, арга хэмжээ байхгүй. ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p> <p><u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай.</u></p>
15		2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх	2017 - 2020		Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээллэдэг болсон байх	<p>ТӨБЗГ – ЗУХ (Төсвийн ерөнхийлөн захирагч)</p> <p>Засгийн газрын тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжсэн ажил, төсөл, арга хэмжээ байхгүй. ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p> <p><u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай.</u></p>

16		1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах	2017 - 2022		Төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаж хэвшсэн байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) ТӨБЗГ-т хамаарахгүй. Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй. Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай.
17	4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх	2018 - 2022		Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангасан байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) ТӨБЗГ-т хамаарахгүй. Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй. Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай.
18	4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2019			ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨБАХ (Бүх шатны төрийн байгууллага) Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас тус байгууллагад учирсан хохирол гарсан тохиолдол үгүй. Өөрийн үнэлгээ: 100 хувь
Зорилт 4. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх						
19	4.1.4.1. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	2017 - 2019			ТӨБЗГ – ЗУХ, МТА, ТӨУЗХ (ТӨБЗГ) Төрийн худалдан авах ажиллагааны газрын чиг үүрэгт хамаарах заалт. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нээлттэй мэдээлэх, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг

						цахим хэлбэрээр зохион байгуулсан. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
20	4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	2017 - 2020		2020 он	ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>
21	бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах	2017 - 2020		2020 он	ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>
22		3. "Цахим худалдан авах ажиллагаа"-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2020		2020 он	ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>

23		4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2019			ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>
24	4.1.4.4. Концесс, шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох	1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох	2017 - 2019			ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>
25	4.1.4.5. Санхүүгийн үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх	3. Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах	2017 - 2019			ТӨБЗГ-т хамаарахгүй. Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцна. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналтай.</u>
Зорилт 6. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх						
26	4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах	4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2018 - 2020		Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажил хэвшсэн байх	(Холбогдох яам, агентлаг) ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u> <u>Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай.</u>

27		5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах	2017 - 2019		<p>ТӨБЗГ – ТӨУЗХ (Холбогдох яам, агентлаг)</p> <p>Засгийн газрын хуралдааны 2021 оны 46 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалт, 2021 оны 01 тоот албан даалгаврын 5.3 дахь заалтаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг "Төрийн өмчийн корпораци" болгон өөрчлөн зохион байгуулах саналыг холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэхийг үүрэг болгож, "Төрийн өмчийн корпораци" нь төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, менежментийг бие даан хараат бусаар шийдвэрлэх тэдгээрийн ашигтай ажиллагааг сайжруулах, төрд ноогдох ногдол ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, хуримтлалын сан үүсгэж томоохон төсөл хөтөлбөрийг нэгдсэн бодлогоор санхүүжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг байх чиглэлийг Засгийн газрын хуралдаанаас өгсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд компанийн засаглалыг сайжруулах асуудалтай холбоотой холбогдох асуудлыг тусгуулахаар ЗГХЭГ-т 2021 оны А-1/939 дугаар албан бичгээр, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2021 оны А-1/4410 дугаар албан бичгээр тус тус санал хүргүүлсэн.</p> <p>ЗГХЭГ, ХЗДХЯ-д хүргүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгуулах гол санал: 1.Хуулийн төслийн 11.5-д хяналтын багцаас доош хэмжээний хувьцаатай компани байж болохоор байгаа тул Төрийн /орон нутгийн/ өмчийн компани гэдэгт төр /орон нутаг/ 100 хувийн хувьцааг нь эзэмшдэг компанийг, төрийн /орон нутгийн/ өмчийн оролцоотой компани гэдэгт төр /орон нутаг/ 99 хүртэлх хувийн хувьцааг эзэмшдэг компанийг хэлнэ гэж оруулах; Ингэснээр төрийн болон орон нутгийн өмчит компани гэх ойлголтод компанийн хувьцааны 100 хувийг төр, орон нутаг эзэмшдэг компани, мөн 99 хүртэлх хувийн хувьцаатай буюу оролцоотой компанийг ч хамтад нь ойлгох боломжтой. 2.Хуулийн төслийн 6.3-ийг "Төрийн болон орон нутгийн өмчит компанийг ач холбогдлоор нь стратегийн ач холбогдолтой компани болон тусгай зориулалтын компани гэж ангилж болно" гэх; 3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Төрийн болон орон нутгийн өмчит хувийн эрх зүйн хуулийн этгээд нь</p>
----	--	--	-------------	--	--

						<p>хөрөнгийн эрхээ өөрөө хэрэгжүүлнэ" гэсэн тул үүнтэй нийцүүлж хөрөнгө олж авах, шилжүүлэх, данс бүртгэлээс хасах, акталж устгах, худалдах шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэдэг байх зохицуулалтыг оруулах; 4. Дагалдан гарах хуулиудын төсөл дутуу байгааг анхаарах. Тухайлбал, энэ хуулийг зөрчвөл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр байх боловч хуулийн төсөл боловсруулагдаагүй байна. Мөн 9.3.4, 16.4-тэй уялдуулж Авлигатай эмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хуульд компанийн засаглалтай холбоотой холбогдох асуудлыг тэдгээрийн бүрэн эрх хэсэгт оруулах эсэхийг анхаарах шаардлагатай.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 хувь</p>
Зорилт 7. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих						
28	4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	2017 - 2019			<p>ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Төрийн бус байгууллага хяналт тавих бүрэн боломжтой. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, тухайлбал тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдсэн. Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл албан ёсны цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбарууд гэх мэт сувгаар мэдээлэгдэж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 хувь</p>
29	санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод,	2018 - 2022		Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн	<p>ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Холбогдох яам, агентлаг)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуулиар хүлээсэн чиг үүргээс төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс санхүүжилт олгосон тохиолдол байхгүй.</p> <p>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</p>

		нээлттэй болгож нийтэд мэдээлэх			байх	Тэмдэглэл: Цаашид хяналтаас хасуулах саналтай. Төсвөөс санхүүжүүлэн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх шаардлага тодорхойлогдоогүй.
Зорилт 10. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зсхион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх						
30	4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	2017 - 2022		Төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 31/696 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийн тайланг гаргаж, ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2112 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд АТГ-ын http://khutulbur.iaac.mn цахим системд төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг, хслбогдох нотлох баримт, материалын хамт оруулан баталгаажуулж, цахим хэлбэрээр мөн тайлагнасан болно.</p> <p>Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн:</p> <p>Төлөвлөсөн нийт арга хэмжээ – 13; Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> – “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 12; – “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай, хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 1 <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дунджаар 97.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үзэлгээтэйгээр тайлагнасан байна.</p> <p>АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг төрийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-нд тус байгууллага хамрагдсан. Уг судалгааны ажлын гүйцэтгэгчээр сонгогдон ажилласан “Эс Ай Си Эй” ХХК төрийн бус байгууллагын судалгааны багтай хамтран ажиллаж, 120 гаруй хүнээс асуумж хэлбэрээр авсан судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар хангасан. Уг судалгаанд суурилсан үнэлгээний дүнгээр ТӨБЗГ нь улсын хэмжээнд 5 дугаарт, Засгийн газрын агентлагийн дүнгээр 3 дугаарт тус тус</p>

					эрэмбэлэгдсэн байна. Өөрийн үнэлгээ: 100 хувь
31	4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх	2017 - 2022	Сургагч багц нарыг үе шаттайгаар сургаж, сургагч багшийн тосг нэмэгдүүлсэн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ (Холбогдсх төрийн болон ТББ)</p> <p>Тайлант оны 4 болон 5 дугаар сард дараах сэдвийн хүрээнд байгууллагын албан хаагчдад дотосд нөөц бололцоонд тулгуурлан өөрийн байгууллагын хуулийн мэргэжилтэн, сургагч багшийн оролцоо хангаж, цар тахлын нөхцөлд видео болон РРt танилцуулга хэлбэртэй сургалтын материал бэлтгэн байгууллагын дотоод сүлжээ, нийгмийн сүлжээн дэх хаалттай бүлгэмд байршуулан хуулийн сургалт, сурталчилгааг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1 Төрийн байгууллага мэдээллийн ил тод байдлаа хэрхэн хангах вэ?; 2 Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтын тухай; 3 Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт; 4 Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт. <p>Мөн “Говь-Алтай АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Ховд АЗЗА” ТӨХК-ийн эрх бүхий албан тушаалтан 10 хүнийг оролцуулсан “Албан тушаалтанд тавигдах хориглолт” сэдвээр цахим сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигын эсрэг сургалтад хуулийн мэргэжилтнийг хамруулж, чадавхийг сайжруулах арга хэмжээ авсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 хувь</p>

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөө"-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтээр тайлагнав. Тайланд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 31 арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг тусган тайлагнасан болно.

Холбогдох нотлох баримт, хүснэгт, фото зураг зэргийг <http://khutulbur.iaac.mn> цахим системийн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан"-ийн сан дахь тухайн арга хэмжээний тайланд файл хэлбэрээр хавсаргасан болно.

Хэрэгжилт тооцсон нийт арга хэмжээ 31, үүнээс:

- "Үр дүнтэй" буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 14;
- "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70 хувьтай хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 3;
- "Үнэлэх боломжгүй" буюу өөрсдөөс хамаарахгүй байгаа арга хэмжээ – 14.

Хэрэгжилтийн дундаж хувь – 94.7 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" үнэлгээтэй байна.

Санал: ТӨБЗГ-ын чиг үүрэгт хамаарахгүй байгаа 12 арга хэмжээг "Үнэлэх боломжгүй" гэж үзсэн бөгөөд цаашид хяналтаас хасуулах саналтай байна. (Арга хэмжээний дугаар: 4.1.3.3.1, 4.1.3.3.2, 4.1.3.4.1, 4.1.3.4.2, 4.1.4.3.1 - 4.1.4.3.4, 4.1.4.4.1, 4.1.1.5.3, 4.1.6.4.4, 4.1.7.3.2 зэрэг болно)

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ДЭД ДАРГА

А.АРИУНБОЛД

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТСОЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ